



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 39

Чойр

Жендерийн эрх тэгш байдлыг хангах
дэд хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жендерийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА

Г.БАТЗАМ





ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээнд тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдахыг хэлнэ.

Монгол Улсын УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын баримт бичгийг батлан нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчимд “...нийгмийнхөгжил, дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчныг бүрдүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшинд эх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэж тус тус тусгасан.

Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд орон нутаг дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн аймгийн хэмжээнд иргэдийн болон орон нутгийн хөгжлийг хангахад чиглэгдсэн 11 дэд хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгүүд батлагдан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаач салбар дундын бодлогыг уялдуулсан жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Жендэрийн дэд хөтөлбөр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн, хүн амын бүлгүүдийн тулгамдсан асуудал, хэрэгцээг судлан бодлого төлөвлөлтөд тусгах, орон нутгийн хөгжилд оролцох нөхцлийг бүрдүүлэх замаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг чанаржуулах арга зам болох юм.

Өнөөгийн байдал

Говьсүмбэр аймаг 17399 хүн амтай. Үүнээс эрэгтэй 8723, эмэгтэй 8676 аймгийн нийт хүн амын доторх хүйсийн харьцаа 50,2:49,8 байна. /2017 оны аймгийн статистик дүнгээр/

Манай аймгийн хувьд 0-79 насны иргэдийн хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй, түүнээс дээш насныхны хувьд эмэгтэй хүйс давамгайлж байна. Хүн амын дундаж наслалт манай аймгийн хувьд 73 байна. Манай аймгийн эрэгтэйчүүдийн дундаж наслалт 72, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.5 байна. Хүйсээр авч үзвэл эмэгтэй хүний дундаж наслалт 3.5 жилээр илүү байна.

Манай аймаг нь 5364 өрхтэй, өрхийн ам бүлийн дундаж тоо 3.1 байна. Өрх толгойлсон хүний тоо 779 үүнээс эрэгтэй 131, эмэгтэй 648 /хүйсийн харьцаа 17:83/ байна.

Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

Говьсүмбэр аймагт төрийн 52 байгууллагад 1309 албан хаагч байгаагаас эрэгтэй 432, эмэгтэй 877 ажилтан ажиллаж байна.

Удирдах албан тушаалд 143 албан хаагч байгаагаас эрэгтэй 71, эмэгтэй 72, /хүйсийн харьцаа 49:50/,

Гүйцэтгэх албан тушаалд 1166 албан хаагч байгаагаас эрэгтэй 361, эмэгтэй 805 /хүйсийн харьцаа 31:69/,

Улс төрийн албан тушаалд 22 албан хаагч байгаагаас эрэгтэй 18, эмэгтэй 4 /хүйсийн харьцаа 82:18/,

Төрийн захиргааны 24 байгууллагын 58 удирдах албан тушаалд эрэгтэй 20, эмэгтэй 38, /хүйсийн харьцаа 34:66/,

Төрийн тусгай 6 байгууллагын удирдах албан тушаалд 18 албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд эрэгтэй 17, эмэгтэй 1 /хүйсийн харьцаа 94:6/,

Төрийн үйлчилгээний 22 байгууллагын удирдах албан тушаалд 45 албан тушаалтан ажиллаж байгаагаас эрэгтэй 16, эмэгтэй 29 /хүйсийн харьцаа 36:64/ тус тус байна.

Орон нутгийн шийдвэр гаргах түвшний хүйсийн харьцааг тодорхойлох

№	Төлөөлөх газар	2012 оны сонгууль			Хүйсийн харьцаа	2016 оны сонгууль			Хүйсийн харьцаа
		Бүгд	Эр	Эм		Бүгд	Эр	Эм	
1	Аймгийн ИТХ	17	14	3	82:18	16	15	1	94:6
2	Баянтал сум	15	9	6	60:40	15	9	6	60:40
3	Шивээговь сум	21	14	7	67:33	21	16	5	76:24
4	Сүмбэр сум	31	23	8	74:26	31	22	9	71:29

2012 оны орон нутгийн сонгуулиар Аймгийн ИТХ-д сонгогдсон 17 төлөөлөгчдөөс эрэгтэй 14, эмэгтэй 3 /хүйсийн харьцаа 82:18/ байсан бол 2016 онд сонгогдсон 16 төлөөлөгчдийн эрэгтэй 15, эмэгтэй 1 /хүйсийн харьцаа 94:6/ байна.

Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн 5 ерөнхий боловсролын сургууль байгаагаас 2017-2018 оны хичээлийн жилд суралцаж буй 3400 суралцагчийн эрэгтэй 1685, эмэгтэй 1715 /хүйсийн харьцаа /49:50/ тус байдлаас харахад охид хөвгүүдийн хүйсийн харилцаа ижил түвшинд байна.

Боловсролын салбарт ажиллагчдын 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд байгаа тул цаашид салбарын жендэрийн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай.

Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж байгаа 602 суралцагчдын хүйсийн харьцааг авч үзэхэд эрэгтэй 462, эмэгтэй 140 /хүйсийн харьцаа 77:23/

Иймд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд зориулсан мэргэжил сонгох, мэргэжил сурталчлах ажлуудыг өргөн хүрээнд зохион байгуулах шаардлагатай.

Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд хийгдсэн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлийн талаарх үндэсний хэмжээний судалгаанаас харахад хамтрагчийн үйлдсэн бие махбодын болон /эсвэл бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь Говьсүмбэр аймагт (39.1%) –тай байгаа нь улсын дунджаас 7,9%-иар илүү байна.

Мөн бусдын зүгээс бие мах бодын хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, Говьсүмбэр аймагт 17.5 /амьдралдаа/ байгаа нь улсын дунджаас 0,2%-иар илүү байна.

Иймд иргэдийн хүчирхийллийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд заавал хуулийн байгууллагад хандаж байх талаар мэдээлэл, танилцуулгыг байнга хүргэх шаардлагатай байна.

2018 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Говьсүмбэр аймагт Жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах сонгон шалгаруулалтын хүрээнд Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Говьсүмбэр аймаг дахь салбар шалгарч жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж орон нутагт дахь эдийн засгийн идэвхтэй хүн амын дунд хийсэн асуулга судалгааны үр дүн болон ганцаарчилсан ярилцлага, иргэний нийгмийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг хийх зэргээр 6 асуумжтай явуулж 115 иргэн хамрагдсан. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаар хүйсийн байдлаас болж ялгавартай хандлагууд ажиглагдсан, жендэрийн талаарх олон

нийтийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх шаардлагатай, ингэснээр нийгмийн хөгжлийг түргэсгэх боломжтой байна.

Үүний тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Орон нутагт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах,
- Төсөл хөтөлбөрт хамрагдах, аливаа үйл ажиллагаанд оролцох иргэдийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах,
- Нас баралтын зонхилох шалтгаан, нөхцөлийн талаар суурь судалгаа хийж, шалтгааныг багасгахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах,
- Гэр бүлийн харилцаанд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Гэр бүл салалт хүүхдийн тэтгэлэг тогтоолт, хүүхэд үрчлэлт, хараа хяналтгүй хүүхдийн хамгаалалт, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг хариуцлага зэрэгт хяналт тавих,
- Орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаандаа нарын оролцоог тодорхой хувиар нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харгалзан энэхүү дэд хөтөлбөрийг Жендэрийн эрх тэгш байдлыгхангахүндэснийхөтөлбөр, холбогдох салбаруудын дэд хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн бодлого төлөвлөлтийг тусгах, эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд орон нутгийн хөгжлийн үйл явцад тэгш оролцож, үр шимийг нь адил тэгш хүртэх боломж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилгоор шино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт:

- 3.1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх
- 3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах
- 3.3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа

Дэд хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлэх бөгөөд жил бүр төлөвлөгөө батлуулж ажиллана.

Тав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх

5.1.1 Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм соёл, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийж, холбогдох байгууллагуудад танилцуулан үйл ажиллагаанд тусгах арга хэмжээ авах

5.1.2 Төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгахад нөлөөлөх;

5.1.3 Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах

5.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах

5.2.1. Удирдах ажилтнууд, манлайлагчдыг жендэрийн сургалтанд хамруулах

5.2.2. Төрийн албан хаагчдыг жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтанд хамруулах, сургагч багш бэлтгэх;

5.2.3. Орон нутагт сургагч багшаар бэлтгэгдсэн албан хаагчдыг бүлэг багаар ажиллуулах төлөвлөгөөг гаргаж, сургалт хийх нөхцлөөр ханган ажиллах жилийн эцэст гарсан үр дүнг нь хэлэлцэж шагнаж урамшуулах

5.2.4. Иргэн аж ахуй нэгж байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг сурталчлах, хялбаршуулсан сурталчилгааны материал, гарын авлага, зөвлөмжийг гаргах

5.2.5. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн асуудлаар олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;

5.2.6. Орлого багатай өрхүүдийг аж ахуй эрхлэх бизнесийн сургалтанд хамруулан, сайн дураараа нэгдэн ажиллахад дэмжлэг үзүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгож, хадгаламж үүсгэх дадал зуршлыг нэмэгдүүлэх;

5.2.7. Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлан урамшуулах

5.2.8. Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнээс орхигдож болзошгүй хүн ам, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмчилгээ сувилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээг өргөжүүлэн, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх

5.2.9. Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага, тасаг, кабинетийн үйлажиллагааг өргөжүүлэх;

5.2.10. Бүх нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш хамруулах, спортоор дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах;

5.2.11. ЕБ-ын 9-12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах;

5.2.12. Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээ зохион байгуулах

5.2.13. Өрх толгойлсон эцэг эх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах

5.2.14. Бизнес эрхлэгчдэд жендер, зохистой хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлаар сургалт зохион байгуулах

5.3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

5.3.1. Боловсролын байгууллагууд уламжлалт ёс заншил, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх мэдлэг олгох;

5.3.2. Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын талаар зорилтот бүлгийн эцэг эх, гэр бүлийн гишүүдэд сургалт зохион байгуулах, хүүхдийн эрхийн зөрчил, бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх тал дээр холбогдох газар, хэлтсүүдтэй хамтран ажиллах;

5.3.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон хүүхдүүдэд сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

5.3.4. Уламжлалт ёс заншлыг орчин үеийн залуу гэр бүлүүдийн соёлд нэвтрүүлэх, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх;

5.3.5. Ганц биеэр амьдарч байгаа өндөр настнуудын аж байдалд тохирсон арга хэмжээ зохион байгуулах

5.3.6. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, бусад арга хэмжээг зохион байгуулах

5.3.7. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг хийх

5.3.8. Малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ.

6.1.1. Жендэрийн талаарх олонт нийтийн хэвшмэл ойлголт өөрчлөгдсөн байна.

6.1.2. Төрийн байгууллагуудын жендэрийн асуудлаар бодлого боловсруулах, төлөвлөх, үнэлэх чадавх сайжирч, байгууллагын удирдах ажилтнууд жендэрийн сургалтанд хамрагдсан байна.

6.1.3. Төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлж, оролцоог хангана.

6.1.4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018)	Зорилтот түвшин (2019)	Зорилто т түвшин (2020)	Зорилто ттүвшин (2021)	Хэрэгжүүлэх байгууллагууд
1	Жендэрийн асуудлаар сургагч багш бэлтгэгдсэн тоо	Тоо	10	15	20	25	Төрийн болон төрийн бус байгууллагууд
2	Хөдөлмөрийн дотоод журамдаа хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	Хувь	-	Нийт төрийн, болон хувийн хэвшлийн байгууллагын 50	Нийт төрийн, болон хувийн хэвшлийн байгууллагын 70	Нийт төрийн, болон хувийн хэвшлийн байгууллагын 100	Төрийн байгууллага ААНБ
3	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага, тасаг, кабинет байгуулах	Тоо	0	1	1	1	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг
4	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендэрт суурилсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн тоо	Хувь	0	2	5	7	Аймгийн ЗДТГ, Жендэрийн салбар хороо
5	Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан тушаалтан	Тоо	20	40	55	60	Жендэрийн салбарт хороо, сургагч багш нар

6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор олгож буй хөнгөлөлттэй зээл авсан өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо	Тоо	0	2	5	7	Аймгийн ЗДТГ, ХХҮГазар
7	Жендэрийн дэд хөтөлбөрийн зорилгыг бодлого төлөвлөлтдөө тусган хэрэгжүүлсэн сум	Тоо	0	3	3	3	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ

**Долоо. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр,
шаардагдах хөрөнгийн хэмжээ санхүүжилтийн эх үүсвэр**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангажжиллах, шаардлагатай төсвийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээнд тусгана.

7.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоод олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар уг хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхийг дэмжинэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

8.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангаж үр дүнг тайлагнах, дүн шинжилгээ хийх, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих, хяналт шинжилгээ үнэлгээ хийх чигүүргийг хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумдын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж, хагас, бүтэн, жилээр үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

8.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь жил бүр хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж жилийн эцэст үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллана.

Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дугаар сарын 29-ны
өдрийн 35 дугаар тогтоолын 0.2 дугаар хавсралт

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Санхүүжилт сая.төг	Хариуцах байгууллага
Зорилт 1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийнүр шимээс тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх						
1.1	Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм соёл, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийж, холбогдох байгууллагуудад танилцуулан үйл ажиллагаанд тусгах арга хэмжээ авах	2019-2021	Судалгаанд тулгуурлан, үр дүн гарсан байна.	100 хувь	ОНХС 3 сая	Аймаг, сумЗДТГ, ЭМГ, ХХУГ, ГБХЗХГазар
1.2	Төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгахад нөлөөлөх	2019-2021	Ялгаварлан гадуурхалтаасангид байна.	100 хувь		Төрхувийнхэв шлийнбайгуул лагууд
1.3	Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	2019-2021	Амьжиргааны түвшин дээшилсэн байна.	100 хувь	ОНХС 2 сая	Аймаг, сумЗДТГХХУГ азар
Зорилт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үрдүнтэй зохион байгуулах						
2.1	Удирдах ажилтнууд, манлайлагчдыг жендэрийн сургалтанд хамруулах	2019-2021	Удирдах ажилтан манлайлагчидсургалт анд сууж чадавхижсан байна.	100 хувь	ОНХС 2 сая	Төр хувийн хэвшлийн байгууллагууд

2	2.2 Төрийн албан хаагчдыг жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх сургалтанд хамруулах, сургагч багш бэлтгэх	2019-2021	Сургагч багш бэлтгэгдсэн байна.	100 хувь	ОНХС 3 сая	Төрийн байгууллагууд, Аймгийн ЗДТГазар
	2.3 Орон нутагт сургагч багшаар бэлтгэгдсэн албан хаагчдыг бүлэг багаар ажиллуулах төлөвлөгөөг гаргаж, сургалт хийх нөхцлөөр ханган ажиллах жилийн эцэст гарсан үр дүнг нь хэлэлцэж шагнаж урамшуулах	2019-2021	3 доошгүй сургалт зохион байгуулсан байна.	100 хувь	ОНХС 2 сая	АЗДТГ
	2.4 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг сурталчлах, хялбаршуулсан сурталчилгааны материал, гарын авлага, зөвлөмжийг гаргах	2019-2021	500 ширхэг гарын авлага тараах материал, зөвлөмж хүргэсэн байна.	100 хувь	ОНХС 2 сая	АЗДТГ
	2.5 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн асуудлаар олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх	2019-2021	2 доошгүй байгууллагатай хамтран ажилласан байна.	100 хувь	ОНХС 2 сая	АЗДТГ
	2.6 Орлого багатай өрхүүдийг аж ахуй эрхлэх бизнесийн сургалтанд хамруулан, сайн дураараа нэгдэн ажиллахад дэмжлэг үзүүлэх, зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгож, хадгаламж үүсгэх дадал зуршлыг нэмэгдүүлэх	2019-2021	Өрхийн орлого дээшилсэн байна.	100 хувь	ОНХС 2 сая	АЗДТГ, ХХУГазар
	2.7 Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга ёс суртахуунтай иргэн болгон төлөшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлан урамшуулах	2019-2021	3 доошгүй гэр бүлийг сурталчласан байна.	100 хувь	ОНХС 2.5 сая	АЗДТГ
	2.8 Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнээс орхигдож болзошгүй хүн ам, зорилтот бүлгийнэ мэтэйчүүдэд үзүүлэх эмчилгээ сувилгааны хүртээмжийг	2019-2021	20 доошгүй иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулсан байна.	100 хувь	ОНХС 1.5 сая	ЭМГазар ЗДТГазар

нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээг өргөжүүлэн, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх	2019-2021	1 доошгүй кабинетийн үйл ажиллагаа тогтворжсон байна	100 хувь	ОНХС 2 сая	ЭМГазар АЗДТ Газар
2.9 Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлэх	2019-2021		100 хувь	ОНХС 2 сая	Биеийн тамир спортынгазар
2.10 Бүх нийтийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулж, эмгэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш хамруулах, спортоор дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах	2019-2021	450 доошгүй сурагчидад сургалт зохион байгуулсан байна.	100 хувь	ОНХС	ХХҮГ, АЗДТГ
2.11 ЕБ-ын 9-12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулах	2019-2021	3 доошгүй байгууллаагын үйл ажиллагааг сурталчилсан байна.	100 хувь	ОНХС 1 сая	АЗДТГ
2.12 Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг анхаарсан байгууллагын үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээ зохион байгуулах	2019-2021	3 доошгүй өрхийн амьжиргааг дээшлүүлсэн байна.	100 хувь	ОНХС 2 сая	АЗДТГ, ХХҮГазар
2.13 Өрх толгойлсон эцэг эх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	2019-2021	20 доошгүй бизнес эрхлэгчидэд сургалт зохион байгуулсан байна	100 хувь	ОНХС	АЗДТГ, ХХҮГазар
2.14 Бизнес эрхлэгчдэд жендер, зохистой хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлаар сургалт зохион байгуулах	2019-2021				
Зорилт 3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх					
3.1 Боловсролын байгууллагууд уламжлалт ёс заншил, охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх мэдлэг олгох	2019-2021	3 доошгүй үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	100 хувь	ОНХС 1.5 сая	ХХҮГазар, АЗДТГ
3.2 Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын талаар зорилтот бүлгийн эцэг эх, гэр бүлийн гишүүдэд сургалт зохион		3 доошгүй сургалт зохион байгуулсан	100 хувь	ОНХС	ХХҮГазар, АЗДТГ,

байгуулах, хүүхдийн эрхийн зөрчил, бүх төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх тал дээр холбогдох газар, хэлтсүүдтэй хамтр анажиллах	2019-2021	байна.	2 сая	ГБХЗХГазар
3.3 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон хүүхдүүдэд сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх "Гэр бүлд зөвлөгөө өгөх" төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх 100 хувь	2019-2021	100-с доошгүй иргэнд зөвлөгөө өгсөн байна.	ОНХС 1 сая	ГБХЗГазар
3.4 Уламжлалт ёс заншлыг орчин үеийн залуу гэр бүлүүдийн соёлд нэвтрүүлэх, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх	2019-2021	3 доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	ОНХС 1 сая	ГБХЗГазар, БСУГ, АЗДТГ
3.5 Ганц биеэр амьдарч байгаа өндөр настангуудын аж байдалд дүн шинжилгээ хийх арга хэмжээ зохион байгуулах	2019-2021	Өндөр настангуудад дэмжлэг тусалцаа үзүүлсэн байна.	ОНХС 1 сая	ХХҮГ, АЗДТГ
3.6 Эмэгтэйчүүд, Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, бусад арга хэмжээг зохион байгуулах	2019-2021	300 доошгүй иргэнд аянд хамрагдсан байх	ОНХС 1 сая	ХХҮГ, АЗДТГ
3.7 Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сурталчилгааг хийх	2019-2021	4 доошгүй сурталчилгаа хийсэн байна.	ОНХС 1.5 сая	ХХҮГ, АЗДТГ
3.8 Малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	2019-2021	100 доошгүй малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.	ОНХС 2 сая	ЭМГазар, АЗДТГ
Нийт дүн			40.0	